

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 30-ны өдөр

№01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг
хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 550464 ширхэг буюу нийт хувьцааны 89,6%-ийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04-р сарын 30-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “2019 онд төлөвлөгөөний дагуу бүхий л боломжоороо ажилласан” гэсэн дүгнэлтийг Хавсралт-1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04-р сарын 30-ны өдөр

№03

Улаанбаатар хот

Хувьцаа хуваах, нэмж хувьцаа гаргах ажлын явцын тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, 51.5, 51.6, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дахь заалт, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.4.1, 5.4.6 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2020 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн Хувьцааг хуваах ажлын явцыг эрчимжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөрд үүрэг болгосугай.

ХОЁР: Хувьцаа нэмж гаргах асуудлыг хөрөнгө оруулагчдын саналыг харгалзан хойшлуулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04-р сарын 30-ны өдөр

№04

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2020 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК нь 2019 онд зардлаа нөхөж чадаагүй, алдагдалтай байгаа болон Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2 дугаар заалтад заасан нөхцөлүүдийг хангахгүй байгаа тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР